

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2022 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Аймгийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2022 оны А/26, сумын Засаг даргын 2022 оны А/20 захирамжийн хүрээнд “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аян сумын хэмжээнд үргэлжлэн зохион байгуулагдаж байна. Өглөө бүрийн нийтийн дасгал хөдөлгөөн тогтмолжиж, 7 хоног бүрийн баасан гарагт нийтийн бүжиг зохион байгуулагдаж байна.

2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын ажлын бэлтгэлийг хангаж, 18-25 насны 78 иргэнд цэргийн зарлан дуудах хуудас тараагаад байна.

Төрийн албан хаагчийн сургалт нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд сумын Засаг даргын тамгын газрын албан хаагчид 3 дугаар шатлалын эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамрагдлаа. ЗДТГ-ын албан хаагчдын 95% эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан.

ЗДТГ-ын дотоод хяналт шалгалтын ажлыг сумын Засаг даргын 2022 оны А/.... захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, батлагдсан удирдамжийн дагуу зохион байгууллаа.

Монголын хүний эрхийн комисс болон Монголын эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулсан “Туслах болон эзэн малчидыг чадавхижуулах сургалт”-д сумын 7 туслах малчин, эзэн малчинг хамрууллаа.

2022 оны 04 дүгээр сарын байдлаар сумын нийт суурин хүн ам 3434, өрх 987, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Энэ сард шинээр төрсөн 4, нас барсан 1 хүн бүртгэгдсэн.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сар бүрийн 8-ны дотор шилэн дансанд байгууллагуудын сарын төсөв гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөө гүйцэтгэл бусад мэдээ мэдээллийг шивж байна.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 /ажиллагсдын цалин тооцооны хуудас/ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг гарган интернетэд шивэн цахимаар илгээсэн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр 2022 онд хийгдэх ажлын жагсаалтад багтсан ЕБС-д тестийн машин худалдан авах /6,0 сая/, Соёлын төвийн тайзны тоног төхөөрөмж худалдан авах /15,0 сая/ ажлууд хуулийн дагуу шууд худалдан авалтаар тус тус хийгдээд байна. Сумын малын тоо толгой албан татварын хөрөнгөөр 2022 онд хийгдэх ажлын жагсаалтад багтсан малын хулгайтай тэмцэх ажилд зориулж сумын цагдаагийн хэсэгт авто машин худалдан авах ажил хийгдлээ.

Мөн хувь хүний хандив тусламжаар ЭМТ суудлын автомашинтай болсон.

Түвшинширээ сум хаврын бүх нийтийн их цэвэрлэгээг 3 дугаар сарын 30,31-нд зохион байгууллаа. Их цэвэрлэгээнд иргэн, аж ахуй нэгж, албан байгууллагууд

идэвхтэй оролцлоо. Нийт 10 машин хог цэвэрлэж төвлөрүүлсэн байна. Хогийн цэгийн хогийг ковшоор цааш нь түрж цэгцлэх ажил хийгдсэн.

3 сарын 30 нд аж ахуй нэгж, байгууллагууд, иргэд хашааны ойр орчимд буюу 50 метр хүртэлх газрын хогоо цэвэрлэсэн. 3 сарын 31 ны өдөр хогийн цэгийн ойр орчимд тархсан хогийг цэвэрлэсэн.

Сумын төвийн тэнэмэл, золбин нохойг устгаж ард иргэдийг аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс 4 сарын 16- нд нохой устгалын ажлыг зохион байгуулав. Нийт 61 нохой устгаж, устгасан нохойг нүхэнд хийж, ариутгал халдваргүйжүүлэлт хийж булсан.

Аж ахуй нэгж, байгууллагуудад хог хаягдал, хог хаягдлын хураамж хураах тухай мэдэгдэл хүргэж ажиллалаа. Хог хаягдлын тухай хуулийг сурталчилж, хог хаягдлын хураамжийг сар бүрийн 25- ны дотор төлж байхаар мэдэгдэл хүргэсэн.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх анхааруулгийг цахим орчинд байршуулсан.

Сумын Засаг даргын А/37 тоот захирамжаар Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийх ажлын 5 хэсэг томилогдон, 4 дүгээр сарын 18-аас дархлаажуулалтыг эхлүүллээ. Ажлын 5 хэсэгт 20 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд тарилга хийх стандарт ажиллагааны заавар /САЗ/-ыг танилцуулж, МЭЭГ-аас зохион байгуулсан цахим хуралд малын эмч нараа оролцуулж, мэдээ мэдээллийг мал эмнэлгийн газарт хүргэж ажиллаж байна. Дархлаажуулалтад одоогийн байдлаар 120 өрхийн 6800 үхэр хамрагдаж, ажлын явц 37 хувьтай байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ: Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д ажил хайгч 84 иргэний мэдээллийг сэргээж бүртгэсэн.

2022 оны 04-р сард 2020-2021 онд төсөл хөтөлбөрт хамрагдсан хөтөлбөрт хамрагдсан 9 иргэн хуваарийн дагуу 3712500 төвлөрүүлэхээс 6 иргэн 2712500 төгрөгийг ХЭДС-ийн 100120037010 тоот дансанд төвлөрүүлсэн.

2022-2023 онд хэрэгжих Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг сумын цахим группүүдээр зар тавьж, сумын ард иргэдийн дунд 4-р сарын 12-ыг хүртэл хугацаанд зарлалаа.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/150 дугаар захирамжаар "Аюулгүй байдал, эрүүл мэндийн соёлыг хамтдаа төлөвшүүлье" уриан дор зохион байгуулагдаж буй "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй"-н сарын арга хэмжээний хүрээнд Монголын үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран сум, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2022 оны 02-р сарын 21-ны өдөр аймагт болсон сургалтад ХАБ-ийн зөвлөлийн 2 гишүүнийг сургалтад хамруулсан

ЕБС-ийн багш ажилчдаас бие бялдарын хөгжлийн сорил авч анализ дүгнэлт хийсэн.

2022 оны 04-р сарын 14-ны өдөр Насан туршийн боловсролын багш сумын ХАБЭА-н зөвлөлийн гишүүдэд "Аюулыг илрүүлэх эрсдлийг арилгах аюул ба эрсдэл" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Хүүхдийн мөнгөний хүсэлтээ бэлнээр авах хүсэлтээр 13 хүүхдийн ехаламж систоємд бүртгэсэн.

Нийгмийн халамжийн тэтгэврийн сунгалт 2 иргэнд, асаргааны тэтгэмж сунгалт-3 иргэнд, 534266 төгрөгийн мэдээллийг "Нөхөн олголтын" жагсаалтаар гарган бэлтгэн өгч нөхөн олгуулсан.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний олголтыг гэрээт дэлгүүрээр 4 өрхөд олголтыг хийж байна. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ халамжаас хөдөлмөрт хүрээнд хамрагдаж байгаа өрхийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, иргэдийн дэлгэрэнгүй судалгаагааг маягтын дагуу гарган хүргүүлсэн.

04-р сард Нийгмийн халамжийн еhаламj системд Нийгмийн халамжийн тэтгэврийн сунгалт 2 иргэн, асаргааны тэтгэмж 6 иргэнд, Цалинтай ээж хөтөлбөрийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмжид 6 иргэнд, Жирэмсэн эхийн тэтгэмжид 5 иргэнд, нийт 19 иргэний мэдээллийг бүртгэж тэтгэвэр тэтгэмжид хамруулсан.

НИЙГМИЙН ДААТГАЛ: Эрүүл мэндийн даатгалд 57 хүний 3893400 төгрөг, сайн дурын даатгалд 74 хүний 16699.9 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 1 байгууллагын 11042.0 төгрөгийн орлого орсон. 4 дүгээр сарын тэтгэвэрт 2 банкаар дамжуулан 416 хүнд 200864479 сая төгрөгийн тэтгэвэр олгосон. Оршуулгын тэтгэмжид 1 хүнд 1000,0 төгрөг олгосон. Шинээр 3 иргэний тэтгэврийн материал хүлээн авч, 2 иргэний тэтгэвэр тогтоогдож, 1 иргэний тэтгэврийн материал хяналтад байна.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР: ЕБС: Улсын олимпиадын 2-ын даваанд Түүхийн хичээлээр 12-р ангийн суралцагч тэргүүн байр, газарзүйн багш мөнгөн медаль, бэлтгэсэн 12-р ангийн суралцагч хүрэл медаль, биологийн хичээлээр 9-р ангийн суралцагч хүрэл медаль, математикийн хичээлээр 11-р ангийн суралцагч мөнгөн медаль хүртлээ.

Зураг технологийн багш "Шидэт бийр" зургийн дугуйлангийн хичээллүүлж байна.

"Дэлхийн номын өдөр"-ийн үйл ажиллагаа үргэлжилж байна. Энэ өдөр дэлхийн 100 гаруй оронд зохиолч, хэвлэн нийтлэгчдэд хүндэтгэл үзүүлэх, ном уншихын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулдаг. Үүний хүрээнд 6-р ангийн сурагчдад номын санд ном унших урилга өгч, суралцагчид номоо уншиж тэмдэглэл хөтлөн, уншсан номынхаа талаар бусдадаа ярьж өгөх үйл ажиллагаа явагдлаа.

"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аян-2022" өдөрлөгийн үйл ажиллагааг Хүүхдийн цэцэрлэгтэй хамтран зохион байгууллаа. Мөн багш ажилчид 7 баг болж "ВОЛЕЙБОЛ"-ын тэмцээн зохион байгууллаа.

"САЙН БАГШИЙН САЙН ТЕХНОЛОГИ" ур чадварын уралдааны 1-р шат амжилттай зохион байгуулагдлаа.

Хүүхдийн цэцэрлэг: Байгууллага болон бүлэг бүр халдвар хамгааллын дэглэмээ баримтлан, хүүхэд хүлээн авахдаа эцэг эхээс эрүүл мэндийн асуумж авч, халууныг үзэж, гарыг ариутгаж мананцаржуулан оруулж хэвшээд байна.

Дээд газраас ирж буй захирамж, тушаал шийдвэр, зөвлөмжийг мөрдөн, хугацаатай бичиг, тоон мэдээг тогтмол цаг хугацаанд нь хүргэн, үүрэг чиглэлийн дагуу ажиллаж байна. Халаалт дулаан хэвийн, 7 хоногийн хүнсний нөөц, түлээ нүүрсний 5-р сарын 15 хүртэл нөөцтэй байна.

Аймгийн БШУгазраас зохион байгуулж буй "САЙН БАГШИЙН –САЙН ТЕХНОЛОГИ" ур чадварын уралдааны 1-р шатыг ажлын байрандаа зохион байгуулж, 1 бүлгийн багш аймагт зохион байгуулагдах 2-р шатанд амжилттай оролцон бүсээсээ шалгарч, дараагийн шатандаа амжилттай оролцлоо.

Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, өдөр тутмын ажлыг засан сайжруулах зорилгоор энэ сард дотоод аудитыг багш, туслах багш, үйлчлэгч, тогооч нарт тусгай удирдамжийн дагуу шалгалт хийлээ.

Мөн БШУГ –ын мэргэжилтний өгсөн зөвлөгөө зөвлөмжийн хэрэгжилт явцад шалгалт хийгдэж бүх багш ажилчид хамрагдлаа. Багш нарыг 7-8 төрлөөр, туслах багшийг 5-6 төрлөөр, тогооч үйлчлэгч нарыг 3-4 төрлөөр шалгуур үзүүлэлт гарган шалгалт хийлээ.

Шалгалтаар багш нар хувийн хавтас болон төлөвлөгөө, төлөвлөлт, эцэг эхтэй ажиллах дэвтэр, ХБХ-тэй ажиллах төлөвлөгөө, төлөвлөлт зэргийг маш сайн хийсэн. Туслах багш нар өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний тэмдэглэл хөтлөлт зарим багш нарт хангалтгүй байлаа. Тогооч нарт технологи карт хоол үйлдвэрлэл, хоолны нэр төрөл нэмэгдээгүй, харин цэвэрлэгээ үйлчилгээ сайжирсан. Үйлчлэгч нарын өдөр тутмын тэмдэглэл хөтлөлт жигдэрсэн цэвэрлэгээ сайжирсан. Багш ажилчид өөрсдийн ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгааны самбарыг ил байршуулсан. Бүлгийн багш туслах багш нар сургалтын төвдөө шинээр хэрэглэгдэхүүн нэмж орчин нөхцлөө сайжруулсан.

Санхүү аудитын өгсөн зөвлөмжийн дагуу ирэх сард төсөв санхүү, хоолны төсөвт тусгай удирдамжийн дагуу шалгалт хийхээр төлөвлөж байна.

ХАБЭА-н тухай хууль, Гал түймрээс урьдчилан сэргийлэх, Эрсдэл гэж юу вэ? сэдэвт сургалтуудыг багш ажилчдад өгч гарын авлага тараалаа. Бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн дунд "Бидний аюулгүй орчин" сэдэвт сургалтыг зохион явуулж сургалтаар өгсөн мэдлэгийг бататгаж танин мэдэхүйн "АХА" тэмцээнийг зохион явуулж 3 хүүхэд хамрууллаа. Анги бүлгүүдэд "Эрсдэлгүй эрүүл орчин" уриатай эрсдлийн үнэлгээг дахин хийж эрсдлийг бууруулан ажиллалаа.

Анги бүлэг болон тоног төхөөрөмжтэй ажилладаг ажилтан бүр өөрсдийн ажилладаг өрөө тасалгааныхаа үүдэнд аюулгүй ажиллагааны зааварчилгааны самбар гарган өглөө бүр ажил эхлэхийн өмнө уншиж танилцан гарын үсэг зурж хэвшсэн.

Мөн аяны хүрээн аймгийн БСУГ-аас өгсөн чиглэлийн дагуу ХАБЭА, хүүхэд хамгаалал, хүнсний чанар эрүүл ахуй, эрүүл ахуй гэсэн 4 чиглэлийн ажлын хэсэг гарган төлөвлөгөө гарган ажиллаж байна. Үүнд замын хөдөлгөөний эрсдлийг тогтоож түүний дагуу шар дарцаг, Эрүүл ахуйн чиглэлээр багш ажилчид хүүхдийн биеийн жингийн индекс гаргаж тооцох, багш ажилчдаас сорил авч үр дүнг тооцох гэх мэт ажлыг, ажлын хэсгүүд хийж гүйцэтгээд байна.

“Багш болон бусад ажилтны ёс зүйн зөрчил арилгах” ажлын хэсгийн 2-р улирлын төлөвлөгөөг гарган батлуулж төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулж ажиллаж байна.

Багшийн ёс зүйн зөвлөлөөс сар бүр Цэцэрлэгийн нийт багш ажилчдад, багшийн ёс зүйн шинэчилсэн дүрэм журмыг танилцуулж, багш ажилтны ёс зүйг ханган ажиллах талаар амлалт, гарын үсэг авч баталгаажуулдаг ба 4-р сарын 22-д нийт 25 багш ажилтанд танилцуулж гарын үсэг авч баталгаажууллаа.

“Харилцаа- мэндлэхээс эхэлнэ” нөлөөллийн аян өрнүүлэн нийт багш ажилчид, бүлгийн хүүхдүүд хамрагдан мэндлэх хүндлэх чадварт сургаж тод дуугаар мэндлэх, мэхийн ёслож мэндлэх дадалд сургаж байна.

“Оны шилдэг уншигч “ шалгаруулах 2022 Судар эгшиглэн төслийн хүрээнд хүүхдийн цэцэрлэгээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Багш ажилчдын амралт чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, тэдний ном унших цагийг нэмэгдүүлэх багш ажилчдад оюуны хөрөнгө оруулалт хийх, сайн уншигчийг тодруулах зорилгоор “Номтой нөхөрлөө” номын тэмдэглэлийн уралдааныг амжилттай зохион байгуулж нийт 25 багш ажилчид номын тэмдэглэлээ ирүүлж 41 ном уншиж тэмдэглэл хөтөлсөн. Эцэг эх хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, цахим орчинд номын соёлыг түгээж, хүүхдүүдээ дэлгэцтэй биш дэлгэсэн номтой нөхөрлөхөд эцэг эхчүүд өөрсдөө зөв үлгэр дуурайлал үзүүлэх зорилгоор “Ухаалаг утаснаас татгалзаж, уншлагын цагтай болцгооё” цахим аяныг өрнүүлж дүгнэлээ. Үүнд 8-н бүлгийн багш 15-н ээж хүүхдэдээ үлгэр уншиж өгөн утга санааг нь ярилцаж, давхардсан тоогоор нийт 43-н үлгэр ярьж, хамтран ярилцсан байна.

СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Аймгийн Засаг даргын 2022 оны А/139 дугаар захирамжийн дагуу аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан бүх нийтийн соёл урлагийн боловсролыг дээшлүүлэх, авьяас чадварыг хөгжүүлэх, тодруулах зорилгоор сумдын дунд зохион байгуулж байгаа урлагийн наадмын бэлтгэл ажлыг эхлээд байна. Урлагийн наадмын бэлтгэл ажил удирдамжийн дагуу 9-н төрөлд, 5-н байгууллага, ЕБС-ийн сурагчид, иргэдийн төлөөлөл ардын авьяастан гэсэн 37-н хүний бүрэлдэхүүнтэй бэлтгэл хийгдэж байна.

Номын сан нь 2022 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу гэрээр ном олголтыг хийх, нутгийн зохиолч, яруу найрагчдын намтар, уран бүтээлийг сурталчлах үйлчлүүлэгчийн тоо хүрээг нэмэгдүүлэх зорилгоор фондын 2000 гаруй номтой үйл ажиллагаагаа явуулж байнгын уншигч-32, ирэгсэд-61, гэрээр 51 ном олгож ажиллалаа. 2022 оноос LiB4U шинэчилсэн программаар үйл ажиллагаагаа явуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Мөн номын сангийн дэргэдэх “Номын клуб” дугуйланг хичээллүүлж байна. “Судар- Эгшиглэн” төсөлд оролцогчдын мэдээллийг нэгтгэн цахимаар сурталчилах ажил хийгдэж байна.

3.2 04р сарын 23-ны өдөр тохиодог “Дэлхийн номын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд төлөвлөгөө гарган дараах ажлуудыг зохион байгуулсан.

- ✓ СӨБ-ийн хүүхдийн цэцэрлэгийн ахлах бүлгийн 35 сурагчдад чанга уншлагыг өрнүүлж тэдэнтэй үлгэрийг хэрхэн ойлгосон талаар хамтран ярилцаж тэдний сэтгэгдлийг сонссон нэгэн үйл ажиллагааг явуулж ажилласан.
- ✓ ЕБС-ийн дотуур байрны суралцагч нарт зөөврийн номын санг аялуулж ном олгон карт нээн ажиллалаа.
- ✓ 04.23-ны “Дэлхийн номын өдөр” өөр фондны номын үзэсгэлэнг гаргасанаар 60 гаруй иргэд, хүүхэд багачууд үзэж сонирхон үйлчлүүлээ.

БМС-нь Соёлын өвийн талаар мэдлэг дээшлүүлж, өвлөн уламжлуулах бүтээлч сэтгэлгээтэй болгох, үндэсний хэл, ёс заншил, өв уламжлалаан эрхэмлэн зөв төлөвшил олгох зорилгоор ЕБС-ийн 6-р ангийн 23 сурагчдад соёлын өв, түүний ангиллын талаар сургалт зохион байгуулсан. Соёлын өвийн талаарх мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд Соёлын өвийн тухай хуулийг цувралаар танилцуулж байна.

Соёлын төвийн 6-н төрлийн дугуйланд нийт 45 сурагчид хамрагдан суралцаж байна. Уламжлалт шагайн харваа сургалтаар 5 сурагч хамрагдан шагайн ерөнхий харвааний талаар мэдлэгжин суралцаж байна. Гар урлалын чиглэлээр 6 сурагч хамрагдан нэхмэлийн утас, нэг удаагийн аяга зэрэг бусад гарын доорх материалыг ашиглан гоёл чимэглэлтэй балны сав зэргийг хийсэн байна.

04 дүгээр сард МУСТА-н дуучин Б.Гүрбадамын “Дурлал шиг бүсгү тоглолт, Сүхбаатар аймгийн “Жаахан шарга театр”-ын уран бүтээлчдийн “Хайрын бэлэг” аялан тоглолт, Дорноговь аймгийн “Яргуй” наадмын дэд байрын шагналт Дэлгэрэх сумын ЕБС-ийн сурагчдын урлагийн тоглолтыг тус тус зохион байгуулагдсан.

Аймгийн засаг даргын 2022оны А/150 дугаар захирамжаар “Аюулгүй байдал, эрүүл мэндийн соёлыг хамтдаа төлөвшүүлье” уриан дор зохион байгуулагдаж буй “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2022” сарын арга хэмжээний хүрээнд байгууллагын ХАБ хариуцсан ажилтан төлөвлөгөө гарган ажлуудыг зохион байгуулж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторийн нийт үзлэг 126, алсын дуудлага 7, гэрийн дуудлага 9, хэвтэн эмчлүүлэгч 23, хэвтэн эмчлүүлэгч Ковид /Халдвартай бүс/ - хэвтэн эмчлүүлсэн өвчтөн -0.

Товлолын вакциныг 32 хүүхдэд хийгээд байна. Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан Өрх сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх Нэн шаардлагтай тусламж үйлчилгээ сургалт семинарт ЭМТ-ийн дарга, эх барих бага эмч, НЭМ-ийн ажилтан нар хамрагдлаа.

Тайлан нэгтгэсэн:

ХЭЗХМэргэжилтэн Ш.Дүүрэнбилэг

Хянасан:Тамгын газрын дарга Ц.Ренчинмядаг